



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2026.04.30 № 08/7176.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Эрдэм шинжилгээний бүтээлийн  
уралдаанд урих тухай


Авлигатай тэмцэх газрын 20 жилийн ойг угтан авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж ирсэн бодлого, үйл ажиллагааны үр дүн, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох, цаашдын бодлого, эрх зүйн орчин, авлигатай тэмцэх арга барилыг боловсронгуй болгох шинэлэг санал, шийдлийг дэвшүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор “Авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааны шинэчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлийн уралдааныг зохион байгуулж байна.

Энэхүү уралдаанд багш, судлаач, магистр, докторын түвшний оюутан болон практик байгууллагын ажилтныг оролцуулан, эрдэм шинжилгээний бүтээлээ ирүүлэхийг урьж байна.

Эрдэм шинжилгээний бүтээлийг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дотор ирүүлэх ба уралдааны удирдамж, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ц.Сэлэнгэтэй 70112402, 99061899 дугаарын утсаар холбогдон авах боломжтой.


Уралдааны удирдамжийг хавсаргав.

Хавсралт 3. хуудастай.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР  Г.АЗЗАЯА



Авлигатай тэмцэх газрын  
2026 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн  
0.8/2.1.76 дугаартай албан бичгийн  
хавсралт



**“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ” СЭДЭВТ  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УДИРДАМЖ**

2026.03.11.

Улаанбаатар хот

**НЭГ. ЗОРИЛГО**

Авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж ирсэн бодлого, үйл ажиллагааны үр дүн, тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох, цаашдын бодлого, эрх зүйн орчин, авлигатай тэмцэх арга барилыг боловсронгуй болгох шинэлэг санал, шийдлийг дэвшүүлэх, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд оршино.

**ХОЁР. СЭДВИЙН ХҮРЭЭ**

2.1. Судлаач дараах ерөнхий сэдвийн хүрээнд бүтээлээ боловсруулна:

1. Авлигын шалтгаан, нөхцөл

- Төрийн албан тушаалын төвлөрөл ба авлигын эрсдэлийн хамаарал;
- Төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын шалтгаан, нөхцөл;
- Төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн засаглал ба авлигын эрсдэл;
- Ашиг сонирхлын зөрчил үүсэх институцийн болон хувь хүний хүчин зүйлс;
- Орон нутгийн засаглал дахь авлигын эрсдэл;
- Төсвийн төлөвлөлт, хуваарилалт дахь ил тод байдал ба авлигын нөхцөл;
- Хяналт, аудитын тогтолцооны сул тал ба авлигын боломж;
- Улс төрийн намын санхүүжилт ба авлигын эрсдэлийн хамаарал;
- Шүүх, прокурорын байгууллагын хараат бус байдал ба авлигын шалтгаан;
- Хүний нөөцийн томилгооны тогтолцоо ба мерит зарчмын хэрэгжилт;
- Цалин, урамшууллын тогтолцоо ба авлигыг өдөөгч хүчин зүйлс.

2. Авлигын үр дагавар

- Авлигын нийгмийн итгэлцэлд үзүүлэх нөлөөлөл;
- Авлига ба эдийн засгийн өсөлтийн хамаарал;
- Авлига ба ядуурал, орлогын тэгш бус байдал;
- Авлига ба төрийн үйлчилгээний чанар, хүртээмж;
- Авлигын улмаас үүсэх хүний эрхийн зөрчил;
- Хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх авлигын нөлөө;
- Авлига ба шударга өрсөлдөөн;
- Авлига ба залуучуудын үнэт зүйл, иргэний оролцоо;
- Авлига ба төрийн институцийн легитим шинж;
- Авлига ба байгаль орчны доройтол (ашигт малтмал, газар ашиглалт гэх мэт);
- Авлигаас үүдэлтэй төсвийн үр ашиггүй зардал.

3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа ба шинэ технологи

- Авлигын эрсдэл ба хиймэл оюун ухаан;
- Нээлттэй өгөгдөл ба ил тод байдлын технологи;
- Блокчейн технологи ба авлигатай тэмцэх үйл ажиллагаа;
- Дижитал мөрдөн шалгах арга зүйн хөгжлийн чиг хандлага;
- Өгөгдөлд суурилсан эрсдэлийн удирдлага ба авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;
- Их өгөгдөл (Big Data) ашиглан авлигын хэв шинжийг илрүүлэх нь;
- Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ба ил тод байдал;
- Цахим мэдүүлгийн системийн үр нөлөө, тулгамдсан асуудал;
- Кибер аюулгүй байдал ба авлигын шинэ хэлбэрүүд;
- Мэдээлэгч (Шүгэл үлээгч)-ийг хамгаалах цахим механизм.

4. Авлига ба цахим засаглал

- Авлигын эрсдэл ба цахим засаглал;
  - Нээлттэй төсөв, шилэн дансны систем, ил тод байдал;
  - Цахим оролцоо (e-participation) ба олон нийтийн хяналт;
  - Цахим гарын үсэг, цахим баталгаажуулалт ба шийдвэр гаргалтын ил тод байдал.
5. Авлига ба Монголын нийгэм, соёл, хүн
- Нийгмийн хандлага, ёс зүй, үнэт зүйл ба авлига;
  - Бэлэг, шан харамжийн уламжлал ба авлига;
  - Ёс зүйн боловсрол ба авлигын эсрэг соён гэгээрүүлэх бодлого;
  - Танил тал, төрөл садны сүлжээ (непотизм) ба авлигын соёл;
  - Олон нийтийн авлигад хандах хүлцэл, тэвчээрийн түвшин;
  - Шударга байдлын талаарх ойлголт ба авлигын талаарх хандлага;
  - Ёс зүйн манлайлал ба байгууллагын соёл;
  - Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээ ба авлигын түвшин;
  - Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба авлигатай тэмцэх үйл ажиллагаа;
  - Иргэний нийгмийн оролцоо ба авлигын түвшин;
  - Боловсролын салбар дахь шударга байдлын асуудал;
  - Компанийн засаглал ба авлигын эрсдэлийн удирдлага;
  - Комплаенсын тогтолцоо ба авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;
  - Авлигын төсөөллийн индекс, түүний зорилго, хязгаарлалт;
  - Жижиг, дунд бизнесийн салбар дахь авлигын эрсдэл;
  - Салбарын онцлог (уул уурхай, барилга, эрүүл мэнд гэх мэт) ба авлигын эрсдэл.
6. Авлигатай тэмцэх эрх зүйн орчин
- Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөө;
  - Ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалтын үр нөлөө;
  - Авлигын гэмт хэргийн ял шийтгэлийн бодлого, үр нөлөө;
  - Олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилт;
  - Авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны онцлог, бэрхшээл;
  - Мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийг хамгаалах эрх зүйн орчин;
  - Улс төрийн албан тушаалтны хариуцлагын тогтолцоо ба авлига;
  - Шүүхийн практик дахь авлигын гэмт хэргийн шийдвэрлэлт;
  - Авлигатай тэмцэх талаарх олон улсын сайн туршлага.

## **ГУРАВ. ОРОЛЦОГЧ**

3.1. Дараах этгээд бие даан болон багаар оролцох боломжтой:

- Их, дээд сургуулийн багш, судлаач
- Практик байгууллагын ажилтан
- Чөлөөт судлаач
- Магистр, докторын түвшний оюутан

## **ДӨРӨВ. БҮТЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

4.1. Бүтээл дараах хэлбэртэй байна:

- Судалгааны өгүүлэл
- Бодлогын судалгаа, дүн шинжилгээ
- Харьцуулсан судалгаа
- Үнэлгээний тайлан

4.2. Бүтээлийн ерөнхий бүтэц

- Гарчиг
- Хураангуй (100-150 үг)
- Түлхүүр үг (5-7)
- Удиртгал (асуудлын үндэслэл, зорилго, зорилт)
- Судалгааны арга зүй
- Судалгааны үр дүн, шинжилгээ
- Дүгнэлт
- Санал
- Ашигласан эх сурвалжийн жагсаалт

#### 4.3. Техникийн шаардлага

- Цаасны хэмжээ: А4
- Хуудас: дээд захаас 15 мм, доод захаас 15 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм
- Хуудасны тоо: 10-18 нүүр
- Үсгийн фонт: Times New Roman
- Үсгийн хэмжээ: 11 pt
- Мөр хоорондын зай: 1.0 (single spacing)
- Эшлэлийн стандарт: АРА
- Нүүр хуудсанд бүтээлийн сэдэв, зохиогчийн нэр, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын болон сургуулийн нэр, мэргэжлийг бичсэн байх.

#### 4.4. Агуулгын шаардлага

- Онол, арга зүйн үндэслэлтэй байх;
- Баримт, статистик мэдээлэлд тулгуурласан байх;
- Шинэлэг санаа, дүгнэлт, бодлогын ач холбогдолтой байх;
- Бүтээлийг урьд өмнө эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлээгүй, ном, сэтгүүлд хэвлүүлээгүй байх;
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх.

#### **ТАВ. УРАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Нэгдүгээр шат: Зохион байгуулах комисс бүтээлийг 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 17:30 цаг хүртэл цахим хэлбэрээр хүлээн авна. Зохион байгуулах комисс, шүүгч нарын баг бүтээлийг урьдчилан тогтоосон шалгуурын дагуу үнэлж, нэгдсэн дүнг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр [www.iaac.mn](http://www.iaac.mn) цахим хуудсаар дамжуулан зарлана.

Хоёрдугаар шат: Эхний шатнаас шалгарсан бүтээлүүдийг эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлэн шилдэг бүтээлийг шалгаруулна. Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх илтгэл, зохион байгуулах хугацааг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр [www.iaac.mn](http://www.iaac.mn) цахим хуудсаар дамжуулан зарлана.

Хоёрдугаар шатнаас шалгарсан шилдэг илтгэлүүдийг ISSN дугаар бүхий “Шударга ёс” сэтгүүлд нийтэлж, олон нийтэд сурталчилна.

#### **ЗУРГАА. ШАГНАЛЫН САН**

- 1-р байр: Өргөмжлөл, 6,000,000 /Зургаан сая/ төгрөг;
- 2-р байр: Өргөмжлөл, 5,000,000 /Таван сая/ төгрөг;
- 3-р байр: Өргөмжлөл, 4,000,000 /Дөрвөн сая/ төгрөг;
- Тусгай байр 1: Өргөмжлөл, 1,000,000 /Нэг сая/ төгрөг;
- Тусгай байр 2: Өргөмжлөл, 1,000,000 /Нэг сая/ төгрөг;
- Тусгай байр 3: Өргөмжлөл, 1,000,000 /Нэг сая/ төгрөг;

#### **ДОЛОО. БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ**

Бүтээлийн цахим хувилбарыг [selenge@iaac.mn](mailto:selenge@iaac.mn) цахим шуудангийн хаягаар 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 17:30 цаг хүртэл хүлээн авна.

Бүтээлийн хэвлэмэл 3 хувийг Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төв (АТҮХХХ-ийн ажилтан, комиссар Ц.Сэлэнгэ)-д 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 17:30 цаг хүртэл хүлээн авна.

Дэлгэрэнгүй мэдээллийг 70112402, 99061899 дугаарын утсаар лавлана уу.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР